



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2013 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 523

Улаанбаатар хот

“Улаанбаатар хотын даатгал” ХХК-д хувь
нийлүүлэгчдийн бүрэлдэхүүн, хувь нийлүүлсэн хөрөнгийн
хэмжээндээ өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 22.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны “Даатгалын компанийн дүрмийн сангийн хэмжээг тогтоох тухай” 355 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Улаанбаатар хотын даатгал” ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг тус компанийн хувь нийлүүлэгч иргэн Ц.Чинбатаас 547,500,000 /таван зуун дөчин долоон сая таван зуун мянга/, М.Энхболдоос 202,500,000 /хоёр зуун хоёр сая таван зуун мянга/, нийт 750,000,000 /долоон зуун тавин сая/ төгрөгөөр тус тус нэмэгдүүлж дараах байдлаар тогтоохыг зөвшөөрсүгэй:

Хувь нийлүүлэгч	Хөрөнгийн хэмжээ /төгрөгөөр/			Дүрмийн санд эзлэх хувь /%/
	Эхний үлдэгдэл	Өөрчлөлт	Эцсийн үлдэгдэл	
1 Ц.Чинбат	1,460,000,000.0	547,500,000.0	2,007,500,000.0	73.0
2 М.Энхболд	500,000,000.0	202,500,000.0	702,500,000.0	25.5
3 НӨХГ	40,000,000.0	-	40,000,000.0	1.5
Нийт	2,000,000,000.0	750,000,000.0	2,750,000,000.0	100.0

2. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд оруулсан өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, компанийн шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэн холбогдох баримтыг 2013 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн дотор Хороонд ирүүлэхийг “Улаанбаатар хотын даатгал” ХХК /М.Энхболд /-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000884